



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/334

Улаанбаатар хот

Г Эмнэлгийн мэргэжилтнүүдийг гепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.1.3.4, Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн 3.1.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих арга хэмжээний хүрээнд шинээр ажилд орсон болон одоо ажиллаж байгаа гепатитийн В вирус халдваргүй эмч, мэргэжилтнийг 2018 оны 9 дүгээр сарын 10-ны дотор багтаан гепатитийн В вирус эсрэг вакцины эхний тунгаар, нэг сарын дараа хоёрдахь тунгаар, 6 сарын дараа гуравдахь тунгаар дархлаажуулах ажлыг холбогдох зааврын дагуу зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2. Гепатитийн В вирус эсрэг вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Гепатитийн В вирус эсрэг вакцинд хамрагдаагүй үлдсэн эмч, мэргэжилтнийг 2018 онд багтаан дархлаажуулалтад бүрэн хамруулахад идэвхи санаачлагатай ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Эрүүл мэндийн ажилтныг гепатитийн В вирус эсрэг дархлаажуулах вакциныг худалдан авахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт үе шаттайгаар тусган, санхүүжүүлэхийг Эдийн засаг, санхүүгийн хэлтэс /Д.Нарантуяа/-т, дархлаажуулах арга хэмжээг жил бүрийн 8 дугаар сард улсын хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081392

Эрүүл мэндийн сайдын 2018  
оны 0.8 дугаар сарын 24-ны  
өдрийн А/33 дугаар тушаалын  
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХУВААРИЛСАН  
ГЕПАТИТИЙН В ВИРУСИЙН ЭСРЭГ ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Аймаг, дүүрэг	Хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоо	Хуваарилсан вакцины тун /1,2,3-р тун/
1.	Архангай аймгийн Эрүүл мэндийн газар	100	300
2.	Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар	250	750
3.	Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар	360	1080
4.	Булган аймгийн Эрүүл мэндийн газар	40	120
5.	Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар	140	420
6.	Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газар	40	120
7.	Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар	210	630
8.	Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар	100	300
9.	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар	80	240
10.	Дундговь аймгийн Эрүүл мэндийн газар	90	270
11.	Завхан аймгийн Эрүүл мэндийн газар	150	450
12.	Орхон аймгийн Эрүүл мэндийн газар	110	330
13.	Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар	160	480
14.	Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар	50	150
15.	Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар	30	90
16.	Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар	80	240
17.	Төв аймгийн Эрүүл мэндийн газар	80	240
18.	Увс аймгийн Эрүүл мэндийн газар	50	150
19.	Ховд аймгийн Эрүүл мэндийн газар	40	120
20.	Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар	160	480

№	Аймаг, дүүрэг	Хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоо	Хуваарилсан вакцины тун /1,2,3-р тун/
21.	Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар	150	450
22.	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	10	30
23.	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	140	420
24.	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	140	420
25.	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	50	150
26.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	210	630
27.	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	110	330
28.	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	120	360
29.	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	10	30
30.	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	270	810
31.	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг	120	360
32.	Улсын I төв эмнэлэг	300	900
33.	Улсыны II төв эмнэлэг	110	330
34.	Улсын III төв эмнэлэг	50	150
35.	Халдварт өвчин судлалын үндэсний төв	200	600
36.	Хавдар судлалын үндэсний төв	30	90
37.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	70	210
38.	Арьсны өвчин судлалын үндэсний төв	50	150
39.	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	100	300
40.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	350	1050
41.	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	20	60
42.	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	20	60
43.	Геронтологийн үндэсний төв	40	120

№	Аймаг, дүүрэг	Хамрагдах эмнэлгийн мэргэжилтний тоо	Хуваарилсан вакцины тун /1,2,3-р тун/
44.	Эмгэг судлалын үндэсний төв	10	30
45.	Хүүхдийн төв сувилал	40	120
46.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	10	30
47.	Уламжлалт Анагаахын Шинжлэх Ухаан Технологи Үйлдвэрлэлийн Корпорацийн Эмнэлэг	40	120
48.	Өргөө амаржих газар	50	150
49.	Хүрээ амаржих газар	70	210
50.	Амгалан амаржих газар	70	210
51.	Нийслэлийн түргэн тусламжийн төв	60	180
52.	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв	20	60
53.	Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв	20	60
54.	Сэргээн засах клиник сувилал	10	30
55.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	30	90
56.	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	50	150
57.	Цэргийн төв эмнэлэг	50	150
58.	Улаанбаатар Төмөр замын төв эмнэлэг	50	150
59.	Бусад эрүүл мэндийн байгууллага (ЭМЯ, ЭМХТ)	50	150
<b>Нийт</b>		<b>5620</b>	<b>16860</b>